

Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчийн тухай ойлголт

1. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч гэж хэн бэ?

Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах /хуулийн 4 дүгээр зүйл/ албан тушаалтныг хэлнэ. /схем 1/

Схем 1.




2. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хаана гаргаж өгөх вэ?

Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлгээ холбогдох байгууллага, албан тушаалтанд дараахь байдлаар гаргаж өгнө.

- Төрийн өндөр албан тушаалтан болон төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах албан тушаалтан Авлигатай тэмцэх газарт;
- Сонгуулийн ерөнхий хороо Ерөнхийлөгчийн, сонгуулийн тойргийн хороо Улсын Их Хурлын, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч Сонгуулийн ерөнхий хороонд;
- Улсын дээд шүүхээс бусад бүх шатны шүүхийн шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлд;
- Засгийн газраас томилогддог албан тушаалтан Төрийн албаны зөвлөлд;
- бусад албан тушаалтаны хувьд түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгнө.

3. ХОМ гаргагчийн үүрэг.

Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу тодорхой үүрэг хүлээнэ. /Схем 2/



4. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчид хүлээлгэх хариуцлага.

- Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл эх үүсвэрийг нь заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар өгч чадаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгана. /Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг/

- Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу санаатай худал мэдүүлсэн бол энэ нь түүнийг албан тушаалаас нь огцруулах, түдгэлзүүлэх, халах үндэслэл болно. /Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дэх хэсэг/

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг бөглөх жишээ, зааварчилгаа

Монгол Улсын Их Хурлын 2007 оны
09 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт

..... -ны хөрөнгө, орлогын мэдүүлэг

Нэг. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал

№	Асуулт	Эцэг/эх/-ийн болон өөрийн нэр	Төрсөн он, сар, өдөр	Эрхэлж байгаа ажил	Ажиллаж, сурч байгаа байгууллага, сургуулийн нэр, хаяг
1.	Мэдүүлэг гаргагч				

***Эцэг/эх/-ийн болон өөрийн нэр** – Овог, нэрийг тодорхой бичих

***Төрсөн он, сар, өдөр** – Төрсөн, он, сар өдрийг тодорхой бичих

***Эрхэлж байгаа ажил** – Өөрийн эрхэлж байгаа ажил, албан тушаалыг тодорхой бичих

***Ажиллаж, сурч байгаа байгууллага, сургуулийн нэр, хаяг** – Хаягийг тодорхой бичнэ. *Жишээ нь: Хууль зүй, дотоод хэргийн яам. Улаанбаатар хот, Худалдааны гудамж 6/1/*

2.	Эхнэр /нөхөр/				
3.	Хүүхэд				
4.	эцэг, эх				

Дээрх хэсгийг “Мэдүүлэг гаргагч” гэсэн хэсэгтэй адилхан бөглөх бөгөөд гэр бүлийн гишүүд нь гадаадад ажиллаж сурж байгаа бол “Эрхэлж байгаа ажил” хэсэгт, аль улсад ажиллаж, сурч байгааг “Ажиллаж, сурч байгаа байгууллага, сургуулийн нэр, хаяг” хэсэгт бөглөнө.

Хүүхэд, Эцэг /эх/ гэсэн мөрөнд мэдүүлэгч нь өөрийн гэр бүлд хамт амьдарч байгаа өөрийн болон эхнэр /нөхөр /-ийн эцэг, эхийн тухай мэдээллийг бичнэ.

Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал гэсэн хэсэгт бөглөгдсөн гэр бүлийн гишүүдийн орлого, хөрөнгийн талаар хөрөнгө, орлогын мэдүүлэгт мэдүүлнэ.

Хоёр. Орлого

/төгрөгөөр/

№	Орлогын нэр	Урьд мэдүүлсэн		Тайлангийн үед орсон өөрчлөлт		Одоо байгаа	
		өөрийн	гэр бүлийн гишүүдийн	өөрийн	гэр бүлийн гишүүдийн	өөрийн	гэр бүлийн гишүүдийн
1.	Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс						
2.	Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого						
3.	Үйл ажиллагааны орлого						
4.	Хөрөнгийн орлого						
5.	Хөрөнгө борлуулсны орлого						
6.	Бусад орлого						

***Урьд мэдүүлсэн** хэсэгт урд оны хөрөнгө, орлогын мэдүүлэгт мэдүүлсэн орлогыг бичих бөгөөд урд онд мэдүүлэг гаргаж байгаагүй бол “мэдүүлж байгаагүй” гэж бичнэ.

***Одоо байгаа** хэсэгт тайлагнаж байгаа тухайн жилийнхээ орлогыг бичнэ.

***Тайлангийн үед орсон өөрчлөлт** хэсэгт урд онд мэдүүлж байсан орлого, тайлагнаж байгаа тухайн жилийнхээ орлогын зөрүүг бичнэ. *Ижишээ нь: Урд оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн орлого хэсэгт үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс нь 2 500 000 төгрөг, тайлагнаж байгаа тухайн жилийнх нь орлого нь 3 000 000 төгрөг бол “Тайлангийн үед орсон өөрчлөлт” хэсэгт +500 000 төгрөг гэж бичнэ. Хэрэв хасагдсан бол “-” тэмдэг тавиад мөнгөн дүнгээ бичнэ/*

Дээрх хэсгийг гэр бүлийн гишүүдийнх мөн адил бичнэ.

***Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс** - Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д заасан “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 11.1.4-д заасан “төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл,

хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого” зэрэг хамаарна.

***Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого** - Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-д заасан “ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого”, 11.1.3-т заасан “ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг”, 11.1.5-д заасан “гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал”, 11.1.6-д заасан “үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого” зэрэг хамаарна.

***Үйл ажиллагааны орлого** - Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасан “эмч, хуульч, өмгөөлөгч, архитекторч, нягтлан бодогч, багш зэрэг мэргэжлээр ажиллаж олсон үйлчилгээний орлого”, 12.1.2-т заасан “хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр олсон үйлдвэрлэл, арилжааны орлого”, 12.2-т заасан “тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлого” зэрэг хамаарна.

***Хөрөнгийн орлого** - Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан “түрээсийн орлого, эрхийн шимтгэлийн орлого */Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасан орлого/,* ногдол ашгийн орлого, хүүгийн орлого, өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийг бусдад ашиглуулснаас олсон орлого” зэрэг хамаарна. Мөн түрээсийн орлогод хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө түрээслүүлсний орлого хамаарна.

***Хөрөнгө борлуулсны орлого** - Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан “үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого, хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого, хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого” зэрэг хамаарна.

***Бусад орлого** - Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан “шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон болон тэдгээртэй адилтгах бусад орлого”, мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан “урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагналын орлого, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, шууд бус орлого” зэрэг хамаарна.

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, бусад орлого гэдгийг 2006 онд батлагдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11, 12, 13, 14, 15, 21, 22 дугаар зүйлд зааснаар ойлгоно.

Энэ хэсгийг бөглөж дуусаад баруун доод буланд гарын үсэг зурж баталгаажуулна.

Гурав. Хөрөнгө, зээл, бэлэг

А. Барилга байгууламж				
№	Барилга, байгууламжийн төрөл	Байршил	Үнийн дүн	Тайлбар
1.				
2.				

***Барилга, байгууламжийн төрөл** - Үйлдвэрийн болон үйлчилгээний барилга, орон сууц, байшин, агуулах, хашаа, гэр гэх зэргээр барилгын төрлийг тодорхойлохын зэрэгцээ барилгын үндсэн хийц, хэмжээг тодорхой бичнэ. /Жишээ нь: 150 м2 талбай бүхий 2 давхар, угсармал төмөр бетон хана, хучилттай үйлдвэрийн барилга, 56 м2 талбайтай 3 өрөө орон сууц, 24 м2 талбайтай дүнгэн байшин, 5 ханатай гэр гэх мэт/

***Байршил** - Тухайн барилга байгууламжийн байршлыг тодорхой бичнэ. /Жишээ нь: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 2-р хороо 3-р хороолол 5-р байр 45 тоот/.

***Үнийн дүн** – Мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар тооцож үнийн дүнг бичнэ.

***Тайлбар** - Тухайн барилга, байгууламжийг хэрхэн олж авсан /худалдаж авсан, өмчлөлөөр авсан, өвлүүлсэн гэх мэт/ талаар эх үүсвэрийн тайлбарыг бичнэ. /Жишээ нь: Худалдаж авсан бол банкнаас урт хугацааны зээл авч худалдаж авсан гэж./ Мөн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дугаар, тухайн хөрөнгийг өмчлөгчийн нэр, онцгой шинж байдлын тухай тайлбар, бусад шаардлагатай мэдээллийг бичнэ.

Б. Авто тээврийн хэрэгсэл					
№	Төрөл, марк	Тоо хэмжээ	Үнийн дүн	Бүртгэлийн дугаар	Тайлбар
1.					
2.					

***Төрөл, марк** - Тээврийн хэрэгслийн төрөл /ачааны автомашин, автобус, кран, чиргүүл г.м/, марк /тоёото ланд круйзер, ниссан санни гэх мэт/-ийг тодорхой бичнэ.

***Тоо хэмжээ** – Тээврийн хэрэгслийн тоог бичнэ.

***Үнийн дүн** - Мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар тооцож үнийн дүнг бичнэ.

***Бүртгэлийн дугаар** - Тээврийн хэрэгслийн гэрчилгээний дугаар, улсын дугаарыг бичнэ.

***Тайлбар** – Тухайн тээврийн хэрэгслийг хэрхэн олж авсан /худалдаж авсан, өвлүүлсэн гэх мэт/ талаар эх үүсвэрийн тайлбарыг бичнэ. Мөн эзэмшигчийн нэр, үйлдвэрлэсэн он, худалдан авсан он, бусад тайлбарыг бичнэ.

В. Мал				
№	Төрөл	Тоо, толгой	Үнийн дүн	Тайлбар
1.				
2.				

Мэдүүлэгч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эзэмшлийн мал, амьтдын тухай мэдүүлнэ.

***Төрөл** - малын төрөл, үүлдэрийг бичнэ.

***Тоо, толгой** - малын тоог тухайн жилд мал тооллогын дансанд бүртгэгдсэн дүнгээр бичнэ.

***Үнийн дүн** - Мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар тооцож үнийн дүнг бичнэ.

***Тайлбар** - тухайн малыг хэрхэн олж авсан талаарх эх үүсвэрийн тайлбар, мал, амьтад байгаа газар, нутаг, эзэмшиж байгаа хүний нэр, онцгой шинж байдлын талаар мэдээлэл, бусад шаардлагатай тайлбарыг бичнэ.

Г. Газар					
№	Газар өмчлөх эрхийн бичгийн дугаар	Байршил /бүс нутаг/	Худалдаж авсан огноо	Үнийн дүн	Тайлбар
1.					
2.					

Мэдүүлэгч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа газрын тухай мэдүүлнэ.

***Газар өмчлөх эрхийн бичгийн дугаар** - Газар өмчлөх, эзэмших эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар зэргийг бичнэ. Газар өмчлөх, эзэмших, ашиглах гэдгийг Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.3, 3.1.4 дэх заалтад заасны дагуу ойлгоно.

***Байршил /бүс нутаг/** - Тухайн газрын байршлыг болон газрын ямар зэрэглэлд хамаарч байгааг тодорхой бичнэ.

***Худалдаж авсан огноо** - Тухайн газрыг худалдаж авсан он, сар, өдөр, хэрэв худалдаж аваагүй бол газар өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээний он, сар, өдрийг бичнэ.

***Үнийн дүн** – Мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар тооцож үнийн дүнг бичнэ.

***Тайлбар** - Эх үүсвэрийн тайлбар, тухайн газрыг өмчлөгч, эзэмшигчийн нэр, бусад тайлбарыг бичнэ.

Д.Хадгаламж			
№	Банк, санхүүгийн байгууллагын нэр	Дүн	Тайлбар
1.			
2.			

Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүдийн эзэмшиж байгаа хадгаламж ийн дүнг тухайн оны жилийн эцсийн дүнгээр мэдүүлнэ.

***Банк, санхүүгийн байгууллагын нэр** - Банк, санхүүгийн байгууллагын нэр, байршил, салбарыг тодорхой бичнэ.

***Дүн** - Хадгаламжийн дүнг төгрөгөөр илэрхийлэн мэдүүлнэ. Хэрэв хадгаламж нь төгрөгөөс бусад валют бол тухайн үеийн ханшаар гадаад валютын дүнг төгрөг рүү хөрвүүлж мэдүүлнэ.

***Тайлбар** - Хадгаламж нь гадаад валютаар байгаа бол валютын төрөл тус бүрээр хадгаламжийн дүнг бичнэ. Түүнчлэн хадгаламжийн мөнгөний эх үүсвэр, эзэмшигчийн нэр, хадгаламжийн төрөл буюу хугацааг бичнэ.

Е. Эрх, концесс, лиценз				
№	Төрөл	Эзэмшигчийн нэр	Орлого	Тайлбар
1.				
2.				

Мэдүүлэгч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчилдөг, эзэмшдэг, ашигладаг зохиогчийн эрх, патент, лиценз, концесс зэрэг хуулиар зөвшөөрөгдсөн онцгой эрхүүдийн талаар мэдүүлнэ.

***Төрөл** – Өмчилдөг, эзэмшдэг, ашигладаг зохиогчийн эрх, патент, лиценз, концесс зэрэг хуулиар зөвшөөрөгдсөн онцгой эрхүүдийн төрөл, нэрийг бичнэ.

***Эзэмшигчийн нэр** - Эзэмшигчийн нэрийг бичнэ.

***Орлого** - Тэдгээрийг эзэмшиж, ашигласнаас олж байгаа орлогын жилийн дүнг бичнэ.

***Тайлбар** - Тухайн эрх, концесс, лицензийг олгосон байгууллагын нэр, эрхийг анх авсан огноо, эрхийн гэрчилгээний дугаарыг бичнэ.

Ж. Хөрөнгө оруулалт, хувьцаа								
№	Хөрөнгө оруулалтын төрөл	Хувьцааны сери, гэрээний дугаар	Хувьцаа гаргасан компани	Хувьцааны тоо	Хувьцааны дүн	Худалдаж авсан үнэ	Ногдол хувь	Тайлбар
1								
2								

Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө оруулж, үүсгэн байгуулсан бүх төрлийн хуулийн этгээдийн талаар мэдүүлнэ. /Тухайлбал, ХК, ХХК, ББН, хоршоо г.м/

Мэдүүлэгч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эзэмшдэг үнэт цаас /хувьцаа, өрийн бичиг, бонд/-ны төрөл, хувьцаа, үнэт цаасны серийн дугаар, хувьцаа гаргасан компанийн нэр, эзэмшиж байгаа хувьцааны тоо, тэдгээрийн нийт үнэ, худалдаж авсан үнэ зэргийг хүснэгтийн асуулгын дагуу бөглөнө.

***Ноогдол хувь** - тухайн үнэт цаасыг эзэмшсэнээс нэгж хувьцаанд авсан ноогдол ашгийн хэмжээг бичнэ.

3. Зээл						
№	Зээлдүүлэгчийн нэр хаяг, бизнесийн үйл ажиллагааны чиглэл	Зээлийн хэмжээ	Зээлийн хүү	Төлж дуусах хугацаа	Зээлийн барьцаа, батлан даагч	Тайлбар
1.						
2.						

Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчийн болон түүний гэр бүлийн гишүүдийн бусдаас зээлсэн мөнгө, зээлийн тухай мэдээллийг энэ хэсэгт бичнэ.

***Зээлдүүлэгчийн нэр хаяг, бизнесийн үйл ажиллагааны чиглэл** - Мөнгө зээлдүүлсэн байгууллага, этгээдийн нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэлийг зээл тус бүрээр тодорхой бичнэ.

***Зээлийн хэмжээ** - Авсан зээлийн хэмжээг бичнэ.

***Зээлийн хүү** - тухайн зээлийн хүүд төлсөн нийт дүн /хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргаж байгаа тухайн оны хувьд/-г бичнэ.

***Төлж дуусах хугацаа** - Тухайн зээлийг төлж дуусахаар гэрээнд заасан хугацааг бичнэ.

***Зээлийн барьцаа, батлан даагч** - Зээлийн барьцаанд тавьсан хөрөнгийн жагсаалт, үнэлгээ, батлан даагчийн нэр, хөрөнгийн жагсаалт, үнийн дүнг бичнэ.

***Тайлбар** - Зээлийг анх авсан огноо, зээлийн хугацаа, зээлийн зориулалт болон бусад шаардлагатай гэсэн мэдээллийг бичнэ.

И. Бэлэг						
№	Эх сурвалжийн нэр, хаяг	Бизнесийн үйл ажиллагааны чиглэл	Авсан бэлгийн товч танилцуулга	Үнийн дүн	Авсан огноо	Тайлбар
1.						
2.						

Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолыг 3.10 дахь заалтын дагуу хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч өөрөө болон түүний гэр бүлийн гишүүдэд гадаад, дотоодын зочин, төлөөлөгч, байгууллага, иргэдээс мэдүүлэг гаргагчийн албан үүрэгтэй нь холбогдуулан

өгсөн, мэдүүлэг гаргагчийн албан тушаалын нэг сарын цалин, хөлснөөс дээш хэмжээний үнэтэй бэлгийг мэдүүлнэ.

Баталгаажуулалт.

Мэдүүлэг гаргагч нь хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтын хуудас болгоны баруун доод буланд гарын үсэг зурах бөгөөд маягтын сүүлийн хуудсанд гарын үсэг, гарын үсгийн тайлал, он, сар, өдрийг бичиж баталгаажуулна.

Таны мэдээлэл маягтын хүснэгтэд багтахгүй тохиолдолд хүснэгтийн тоог нэмж болно.